



ДОРНОГОВЬ АЙМАГ  
ХАТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/112

Амна-Ус

Газар ашиглуулах дуудлага  
худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.17 дахь заалт, 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/188 дугаар “Аргачлал шинэчлэн батлах тухай” тушаал, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны “Газар зохион байгуулалтын 2026 оны төлөвлөгөөнд нэмэлт оруулах тухай” 09/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын газар зохион байгуулалтын 2026 оны төлөвлөгөөний дагуу хавсралтад дурдагдсан газруудад ашиглуулах эрхийн дуудлага худалдааг зохион байгуулсугай.

2.Газар ашиглуулах дуудлага худалдааг зохих журмын дагуу 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулахыг Газрын даамал (М.Ууган-Эрдэнэ)-д даалгасугай.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Ч.Хишиг-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.НАРАНМӨНХ



My com.D/2026on/A Zahiramj

222602208

Хатанбулаг сумын Засаг даргын 2026 оны  
05... дугаар сарын 19 өдрийн 112 дугаар  
захирамжийн хавсралт



**ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЖУРМААР АШИГЛУУЛАХ ГАЗРЫН БАЙРШИЛ,  
ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ, ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ЗАРЛАХ ҮНЭ**

Д/д	Баг	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Газрын байршил	Газрын хэмжээ (м2)	Газрын зориулалт	Дуудлага худалдааны анхны үнэ (төгрөг)	Дэнчингийн хэмжээ (төгрөг)
1	5-р баг	5112477	Амна-Ус	295232	Цахилгаан, эрчим хүч дамжуулах шугам	5904640	590464
2	5-р баг	5112478	Амна-Ус	34960	Цахилгаан, эрчим хүч дамжуулах шугам	699200	69920
3	5-р баг	5112479	Амна-Ус	52490	Цахилгаан, эрчим хүч дамжуулах шугам	1049800	104980
Нийт				382682		7,653,640	765,364